





Монгол улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд


2018.09.28

*Энэхүү судалгааны ажилд дурьдах аливаа дүгнэлт нь
хувь судлаачийн байр суурийг илэрхийлнэ.*



 Монгол улсын гадаад худалдааны бодлогын түүх

 Монгол улсын гадаад худалдааны бодлогын өнөөгийн нөхцөл байдал


 Гадаад худалдааны бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө, ач холбогдол

 Дүгнэлт, зөвлөмж

1.1. Гадаад худалдааны бодлогын түүх

- Манай улсын гадаад худалдаа 1920-1960-аад оны үед зөвхөн Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) руу чиглэсэн бүтэцтэй байсан бол 1960-аад оноос 1990-ээд он хүртэл Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн хүрээгээр хязгаарлагдаж байлаа.
- 1989 он гэхэд манай улсын нийт гадаад худалдааны 90 хувийг ЭЗХТЗ-ийн орнууд, үүнээс 79 хувийг ЗХУ-тай хийсэн худалдаа эзэлж байв. Үлдсэн 10 хувийг БНХАУ, Япон, Швейцарь, Австри, Их Британи, Итали зэрэг цөөхөн улстай хийсэн худалдаа эзэлж байв.

Зураг 1 | Гадаад худалдааны нийт эргэлт /1989 онд, орноор/




Эх сурвалж: Монгол улс зах зээлд статистикийн эмхэтгэл, УБ 2004



1.1. Гадаад худалдааны бодлогын түүх

Зураг 2 | Худалдааны асуудал эрхэлсэн төрийн байгууллага /1921-1990/



- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед **худалдааны салбарыг чухал ач холбогдолтой салбар** хэмээн үзэж тухайн цаг үеийн нөхцөл байдал, онцлогт тохируулсан худалдааны асуудал эрхэлсэн төрийн байгууллагыг ажиллуулж байсан.

Эх сурвалж: www.vip76.mn



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

1.1. Гадаад худалдааны бодлогын түүх

Зураг 3 | Гадаад худалдааны нийт эргэлт /1992 онд, орноор/




Эх сурвалж: Монгол улс зах зээлд статитикийн эмхэтгэл, УБ 2004

- 1991 оны 6 дугаар сард ЭЗХТЗ албан ёсоор татан буугдсанаар ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийсэн худалдаа 1989 онд 90 хувь байсан бол 1992 онд 57 хувь болж огцом буурч, манай улс худалдааны шинэ түншүүдтэй болсон.
- Өрсөлдөөн ихтэй зах зээл дээр худалдааны өөр шинэ түншүүдийг олох, гадаад зах зээлд нэвтрэх шаардлага тулгарсан тул Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д 1997 оны 1 дүгээр сард элссэн.
- ДХБ-ын гишүүн орон болсноор Монгол улс дэлхий зах зээлд нэвтрэх илүү таатай, найдвартай гарц үүссэн бөгөөд олон талт хамтын ажиллагааны хүрээнд бусад улс оронтой хамтран худалдааны зорилтуудыг биелүүлэх боломж бүрдсэн.



2.1. Монгол улсын эдийн засгийн бүтэц


Зураг 4 | Голлох экспортлогч болон импортлогчид /бүс нутгаар, 2017/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Экспортлогч орноор харьцуулан харвал **Хятад** улс **86%**-ийн худалдааг дангаар гүйцэтгэсэн.
- Импортлогч орноор харьцуулан харвал **33%**-ийг эзэлж буй хамгийн том импортлогч нь **Хятад** улс байна.

Зураг 5 | Экспорт болон импортын цаашдын хандлага



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк

- Өсөлтийн хандлагуудаас харахад экспорт болон импортын нийлбэрээр тодорхойлогдох **гадаад худалдааны эргэлт** нь **ДНБ-ий өсөлтөд** дунд хугацаанд их хэмжээний нөлөө үзүүлэхээр байна.



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

2.1. Монгол улсын эдийн засгийн бүтэц

Зураг 6 | Дотоодын нийт бүтээгдэхүүний салбараарх бүтэц /хувиар/



- Эдийн засгийн салбарыны бүтцийг авч үзвэл сүүлийн 7 жилийн дунджаар уул уурхайн салбар 19.06%, **бөөний болон жижиглэн худалдааны салбар 18.07%**, хөдөө аж ахуйн салбар 11.93% ба **боловсруулах үйлдвэрлэлийн салбар 9.57%**-ийг эзэлж байна.
- Худалдааны салбарын эзлэх хувь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувиас **2 дахин их** байгаа нь үйлдвэрлэлээс илүүтэй худалдаа эрхлэх хандлага зонхилж байгааг илэрхийлнэ.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

2.2. Гадаад худалдааны бодлогын өнөөгийн нөхцөл байдал

№	Хууль, журам	Хэрэгжилт
1	"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөр /Засгийн газрын 2007 оны 131 тогтоол/	Хэрэгжилт хангалтгүй байсантай холбогдуулан 2018 онд баталсан "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-д дахин тусгаж өгсөн.
2	"Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах" хөтөлбөр /Засгийн газрын 2009 оны 324 тогтоол/	2015 онд Засгийн газрын 474 дүгээр тогтоолоор баталсан "Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр"-өөр энэхүү хөтөлбөрийг хүчингүй болгосон.
3	"Экспортыг дэмжих хөтөлбөр" /Засгийн газрын 2013 оны 239 дүгээр тогтоол/	Хөтөлбөрийн хэрэгжилт 18 хувьтай гарсантай холбогдуулан засгийн газар 2016 онд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж "Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг баталсан.
4	"Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа"-ны хөтөлбөр /Засгийн газрын 2015 оны 474 тогтоол/	Хөтөлбөрийг 2015-2020 оны хооронд хэрэгжүүлнэ.
5	"Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр" /Засгийн газрын 2016 оны 211 тогтоол/	Хөтөлбөрийг 2016-2020 оны хооронд хэрэгжүүлнэ.
6	Худалдааны тухай хууль	УИХ-ын байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэгдсэн хэдий ч батлагдаагүй.
7	"Монгол экспорт" хөтөлбөр	Хөтөлбөрийг 2018-2022 оны хооронд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Манай улсын засгийн газраас сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих зорилтын хүрээнд олон бодлого, хөтөлбөр баталсан хэдий ч **үр дүнтэй, биелэлт сайтай бодлого, хөтөлбөр алга байна.** Энэ нь манай улс **худалдааны нэгдсэн бодлогогүй, бодлого боловсруулалт, хэрэгжилтийг хариуцсан газар байдаггүйтэй холбоотой юм.**



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

2.3. Олон улсын хамтын ажиллагаа

Монгол улсын гадаад худалдааны бодлогыг Гадаад харилцааны яамны “Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар” хариуцан ажиллаж байна.

Зураг 7 | Гадаад харилцааны /2016/

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ



Эх сурвалж: Монгол улсын Гадаад харилцааны яам

Хүснэгт 1 | Түншлэлийн харилцаатай улсууд

Түншлэлийн харилцаа	Түнш улс	Тайлбар:
Иж бүрэн түншлэлийн харилцаа	БНХАУ	Улс төр, Худалдаа, эдийн засаг, боловсрол, стратегийн эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар болон бүс нутгийн хүрээнд хамтарч ажиллана.
Стратегийн түншлэлийн харилцаа	ОХУ, Япон, Энэтхэг	2 улсын харилцааны хүрч болох хамгийн дээд түвшний харилцааг хэлнэ.
Иж бүрэн түншлэлийн харилцаа	БНСУ, АНУ, Герман, Түрк	Стратегийн түншлэлд хараахан хүрдэггүй боловч нийгмийн бүх салбарт хамтран ажилладаг түншлэл.
Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа	Канад, Австрали	Нийгмийн зарим салбарт

Эх сурвалж: Монгол улсын Гадаад харилцааны яам статистик

Монгол улс дараах 10 улстай түншлэлийн харилцаа тогтоон, харилцаж байна.



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

2.3. Олон улсын хамтын ажиллагаа

Хүснэгт 2 | ДХБ-д нэгдсэнээс хойших хоёр улсын хамтын худалдааны хэлэлцээр

Хэлэлцээр	Огноо	Тайлбар
Европын эдийн засгийн нийгэмлэг болон Монгол улсын засгийн газар хоорондын нэхмэлийн салбар дахь худалдааны гэрээ	1997/12/31	Монголын оёдлын бүтээгдэхүүнийг дэмжих
Вьетнам болон Монголын Засгийн газрын хоорондох худалдааны гэрээ	1999/12/13	Худалдаа, тээвэр, соёлын хувьд хамтран ажиллах
Куба болон Монголын Засгийн газрын хоорондох худалдааны гэрээ	2001/09/11	2 улсын хоорондын худалдаанд нэмэлт худалдааны хязгаарлалт хийхгүй
АНУ болон Монголын Засгийн газрын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны гэрээ	2004/05/15	Хамтын худалдаа, хөрөнгө оруулалтын консул байгуулж, 2 улсын цаашдын худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжин ажиллах
АНУ болон Монголын Засгийн газрын хоорондох олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээр	2013/09/24	Худалдаанд сөргөөр нөлөөлж буй саадыг арилгах талаар санал солилцох
Монгол улс, Япон улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр	2015/2 сар	Эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан эдийн засаг болоод худалдаанд түлхэц үзүүлэх

Монгол улс ДХБ-д нэгдсэнээс хойш хоёр улсын хамтын худалдааны дараах цөөн хэдэн хэлэлцээрүүдийг хийсэн байна.

Эх сурвалж: Монгол улсын Гадаад харилцааны яам статистик



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.1. Гадаад худалдааг дэмжих ба хөнгөвчлөх үйл ажиллагаа-Логистикийн гүйцэтгэлийн индекс

Хүснэгт 3 | Монгол улсын Логистикийн гүйцэтгэлийн индекс, 2007-2018

Он	LPI эзэлсэн байр	LPI ерөнхий үзүүлэлт	Гааль	Дэд бүтэц	Олон улсын тээвэрлэлт	Логистикийн өрсөлдөх чадвар	Ачаа тээвэрлэлтийн мэдээлэл	Цаг хугацаа
2018	130	2.37	2.22	2.10	2.49	2.21	2.10	3.06
2016	108	2.51	2.39	2.05	2.37	2.31	2.47	3.40
2014	135	2.36	2.20	2.29	2.62	2.33	2.13	2.51
2012	140	2.25	1.98	2.22	2.13	1.88	2.29	2.99
2010	141	2.25	1.81	1.94	2.46	2.24	2.42	2.55
2007	136	2.08	2.00	1.92	2.50	1.80	2.00	2.25


• Хүснэгт 3 нь Монгол улсын **Логистикийн гүйцэтгэлийн индексийн** утгыг харуулж байна.

• Монгол улс 2016 онд LPI индексийн ерөнхий үзүүлэлтийн дүнгээр 160 орноос 108 дугаар байранд буюу 2014 оноос 27 байраар урагшилсан хэдий ч **2018 онд 22 байраар хойшлон 130 дугаар байрт** жагссан байгаа нь тааруу үзүүлэлт юм.

• LPI индекс буурахад **гаалийн байгууллагын үйл ажиллагаа, ачаа тээвэрлэлтийн мэдээлэл болон цаг хугацааны үзүүлэлтүүд** нөлөөлжээ.

Эх сурвалж: Дэлхийн банк, LPI

Зураг 8 | Олон улсын логистикийн гүйцэтгэлийн индекс, сонгосон орноор, 2018



• Зураг 8-д Манай улсын 2018 оны LPI индексийг **хөрш орнууд болон бүс нутгийн индекстэй** харьцуулан харууллаа.

• Монгол улс логистикийн гүйцэтгэлийн индексийн бүх үзүүлэлтээр **БНХАУ, ОХУ болон Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас доогуур, бага түвшинд** байна.

Эх сурвалж: Дэлхийн банк, LPI



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.1. Гадаад худалдааг дэмжих ба хөнгөвчлөх үйл ажиллагаа-Логистикийн гүйцэтгэлийн индекс

Хүснэгт 4 | Монгол ба Герман улсын дотоодын логистикийн гүйцэтгэлийн индекс 2016

Үзүүлэлт	Монгол	Герман
Боомт нисэх буудлын нийлүүлэлтийн хэлхээ /Экспортын хугацаа, зай/		
Зай (километр)	86 км	259 км
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	4 өдөр	3 өдөр
Хуурай газрын нийлүүлэлтийн хэлхээ /Экспортын хугацаа, зай /		
Зай (километр)	1181 км	631 км
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	16 өдөр	3 өдөр
Боомт нисэх буудлын нийлүүлэлтийн хэлхээ /Импортын хугацаа, зай/		
Зай (километр)	75 км	285 км
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	4 өдөр	3 өдөр
Хуурай газрын нийлүүлэлтийн хэлхээ /Импортын хугацаа/		
Зай (километр)	772 км	1043 км
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	12 өдөр	4 өдөр
Шаардлага хангасан тээвэрлэлт (%)	88%	94%
Экспортын үйл ажиллагаатай холбоотой агентлагуудын тоо	3	2
Импортын үйл ажиллагаатай холбоотой агентлагуудын тоо	4	2
Экспортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын тоо	3	2
Импортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын тоо	4	2
Биет үзлэг хийгдэхгүй гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	1 өдөр	1 өдөр
Биет үзлэг хийгдэх гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	1 өдөр	2 өдөр
Биет үзлэг (%)	27%	3%
Олон төрөлт (%)	9%	2%

• Герман улсын хувьд гаалийн байгууллагын үйл ажиллагааны түргэн шуурхай байдал, дэд бүтцийн тааламжтай нөхцөл, олон улсын тээвэрлэлт хийх чадамж, ачаа тээврийг хянах механизм нь харьцангуй өндөр түвшинд хөгжиж чадсан байна.

• Монгол улсын хувьд гадаад зах зээл рүү гарах хилийн боомт цөөн, гадаад худалдаанд шаардлагатай бичиг баримтын тоо их, тэдгээрийг олгох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоо сул, дэд бүтцийн сул хөгжил, ачаа барааг хянаж шалгах систем бүрэн хөгжөөгүй байна.

Эх сурвалж: Дэлхийн банк, LPI



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.1. Гадаад худалдааг дэмжих ба хөнгөвчлөх үйл ажиллагаа-Бизнес эрхлэлтийн индекс

Хүснэгт 5 | Монгол улсын Бизнес эрхлэлтийн индекс, эзлэх байраар 2016-2018

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он
1	Ерөнхий үзүүлэлт	62	64	62
2	Бизнес шинээр эхлүүлэх	32	36	59
3	Барилгын зөвшөөрөл авах	26	29	23
4	Цахилгаан эрчим хүчний хангамж	136	137	139
5	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл	45	46	50
6	Зээл авах боломж	60	62	20
7	Хөрөнгө оруулагчдыг хамгаалах	22	26	33
8	Татвар төлөлт	73	35	62
9	Хилийн дагуух худалдаа	102	103	110
10	Гэрээний биелэлт	83	85	88
11	Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт	87	91	93

Эх сурвалж: Дэлхийн банк, Doing Business

• Монгол улс Бизнес эрхлэлтийн индексийн ерөнхий үзүүлэлтээр **2018 онд 190 орноос 62 дугаар байранд** жагссан байна.

• Уг тайлангийн сүүлийн 3 жилийн үр дүнгээс харахад манай улсын зээл авах боломжийн шалгуур үзүүлэлт сайжирсан бол **бусад үзүүлэлтүүдийн хувьд 2-20 байраар ухарсан** байна.

• **Хил дамнасан худалдааны үзүүлэлт** нь бусад үзүүлэлтүүдээсээ доогуур буюу 2018 онд **110 дугаар байрт жагсаж** өмнөх оноос 7 байр ухарсан байна.



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.1. Гадаад худалдааг дэмжих ба хөнгөвчлөх үйл ажиллагаа-Бизнес эрхлэлтийн индекс

Хүснэгт 6 | Монгол улсын экспорт, импортын цаг хугацаа, зардлын мэдээлэл, 2016-2018

Үзүүлэлт	Монгол улс			Өндөр орлоготой OECD-н орнууд	Зүүн Ази, Номхон далайн улс орнууд
	2016	2017	2018	2018	2018
Экспортын цаг хугацаа: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цаг/	37	62	62	12.7	55.9
Экспортын зардал: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам.доллар/	41	191	191	149.9	387.5
Экспортын цаг хугацаа: бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цаг/	115	168	168	2.4	68.2
Экспортын цаг хугацаа: бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам доллар/	64	64	64	35.4	112.1
Импортын цаг хугацаа: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цаг/	22	48	48	8.7	70.5
Импортын зардал: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам.доллар/	60	210	210	111.6	431
Импортын цаг хугацаа: бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цаг/	115	115	115	3.5	65.6
Импортын цаг хугацаа: бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам доллар/	83	83	83	25.6	111.4

Эх сурвалж: Дэлхийн банк, Doing Business

• Монгол улсын экспортын худалдааны хувьд **хил дээрх зөвшөөрөл авах, бичиг баримт бүрдүүлэх үйл ажиллагаанд зарцуулж буй цаг хугацаа** өндөр орлоготой OECD-н улс орнууд төдийгүй бүс нутгийнхаа улс орнуудаас **өндөр байна.**

• Манай улсад бараа бүтээгдэхүүн экспортод гаргахад **11 төрлийн бичиг баримт бүрдүүлж, 168 цаг** зарцуулдаг бол импортод **12 төрлийн бичиг баримт шаардаж, 115 цаг** зарцуулж байна (Д.Адъяасүрэн, 2018).

• Олон төрлийн зөвшөөрөл авах, бичиг баримт шаардах зэрэг нь экспортын худалдааны саад болж байгаагаас үүдэн **экспортын барааны нэр төрлийг нэмэгдүүлэх, экспортын худалдааг өргөжүүлэх боломжийг хязгаарласаар байна.**



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.2. Гадаад худалдааны бодлогын нөлөөллийн үзүүлэлтүүд

Зураг 9 | Худалдааны гэрээ хэлцлийн ач холбогдол /худалдаанд эзлэх хувь хэмжээ, 2016/



Эх сурвалж: UNCTADSTAT, WTO RTAIS, COMTRADE тоон өгөгдөл

• Зураг 9 нь тухайн улсын гадаад худалдаанд эзлэх худалдааны **гэрээ хэлцлээр** хийгдсэн арилжааны хувийг харуулна.

• Худалдааны гэрээ хэлцэл нь гадаад худалдааны бодлогын чухал хэрэгсэл болох ёстой бөгөөд худалдааны гэрээ хэлцлийг **хөгжингүй орнуудад өргөнөөр ашигладаг** бол ихэнх **хөгжиж буй орнуудад** тэр бүр **ашиглаж чаддаггүй** байна.

• Монгол улсын хувьд худалдааны гэрээ хэлцлийг тэр бүр ашигладаггүй нь нөгөө талаар Монгол улсын гадаад худалдааны **бодлогын идэвхжил дутмаг** байдагтай холбоотой юм.



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

Зураг 10 | Худалдааны хамгаалалтын хэмжүүр /2016/



Эх сурвалж: UNCTAD, WTO I-TIP тоон өгөгдөл

• Зураг 10 нь улс орнуудын худалдааны хамгаалалтын хэмжүүрийн хэрэглээг харуулна.


• Худалдааны хамгаалалтын хэмжүүр нь ихэвчлэн хөгжиж буй болон хөгжингүй орнуудад ашиглагддаг бөгөөд Хятад, Европын холбоо болон Америк улсуудад үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний эсрэг хэрэглэгдэж байна.

• Монгол улс худалдааны хамгаалалтын арга хэрэгслийг идэвхитэй хэрэглэдэггүй. Энэ нь худалдааны нээлттэй байдалд эерэг нөлөөтэй хэдий ч үндэсний аюулгүй байдал алдагдах, зарим орны худалдаанаас хэт хараат байдалд орох эрсдэлийг дагуулдаг.



3.2. Гадаад худалдааны бодлогын нөлөөллийн үзүүлэлтүүд

Зураг 11 | Урт хугацааны алдагдал /2006 оноос хойш урсгал тэнцлийн алдагдалтай жилийн тоо/



Эх сурвалж: UNCTADSTAT, IMF санхүүгийн статистик

• Зураг 11 нь улс орнуудын 2006 оноос хойш **урсгал тэнцлийн алдагдалтай** явсан жилийн тоог харуулна. .

• Олон жил дараалан **худалдааны алдагдалтай** явсан улсууд нь эдийн засгийн гэнэтийн шокуудад **илүү өртөмтгий** байх хандлагатай байдаг.

• Монгол улс сүүлийн 10 жилийн хугацааны **9-д нь урсгал тэнцлийн алдагдалтай** байжээ.



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

Зураг 12 | Экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс /2016/



Эх сурвалж: UNCTADSTAT, IMF санхүүгийн статистик


• Энэхүү индекс нь **1**-тэй тэнцүү тохиолдолд тухайн улс зөвхөн **1 төрлийн** бүтээгдэхүүн экспортолдог, **0**-тэй тэнцүү тохиолдолд тухайн улс **бүх төрлийн** бүтээгдэхүүнийг ижил дүнгээр экспортолдог гэсэн үг юм.

• Байгалийн баялаг ихтэй хөгжиж буй орнуудын экспорт нь хэт нэг салбар дээр тулгуурласан байдаг тул эдийн засаг нь гадаад шоконд хэт өртөмтгий болдог.

• Монгол улсын **экспортын төвлөрөл** маш **өндөр** байна.



Зураг 13 | Доллартай харьцах ханшийн өөрчлөлт /2010-2016/



Эх сурвалж: UNCTAD, IMF санхүүгийн статистик

• Зураг 13-д улс орнуудын мөнгөн тэмдэгтийн доллартай харьцах ханшийн 2010-2016 оны өөрчлөлтийг харууллаа.

• Олон улсын худалдаа, арилжаа ихэвчлэн доллараар хийгддэг тул долларын ханшийн өсөлт, бууралт нь улс орнуудын өрсөлдөх чадварыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

• Монгол улсын төгрөгийн доллартай эсрэг харьцах ханш 2010-2016 оны хооронд хүчтэйгээр суларчээ.



Гадаад худалдааны бодлогын хэрэгслийн идэвхжилтийг тодорхойлогч хүчин зүйлс



Гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд




1 Дээрх гадаад худалдааны бодлоготой холбоотой макро үзүүлэлтүүдийн нэгтгэлээс манай улсын гадаад худалдааны бодлогын идэвхжилт, хэрэгжилт болон үр дүн тун хангалтгүй байгааг дүгнэж болохоор байна.

2 Гадаад худалдааны сөрөг үр дагавруудыг бууруулахад чиглэсэн бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх механизмыг тодорхой зааж өгөх шаардлагатай юм.



3.3. Улс орнуудын гадаад худалдааны бодлогыг хариуцдаг нэгж

Хүснэгт 7 | Улсуудын гадаад худалдаа хариуцдаг яамд /2018 оны 7-р сар/



Нийт 205 улсын хувьд авч үзэхэд улсуудын дийлэнх нь буюу 95% (195 улс) нь худалдааны яамтай, үүний дотор 25% нь (51 улс) гадаад худалдааг дангаар хариуцан ажилладаг яамтай байна.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.4. Олон улсын туршлага (Өмнөд Солонгос Улс)

Хүснэгт 8 | Солонгос улсын гадаад худалдааг дэмжих төлөвлөгөө



Эх сурвалж: (Yong-Shink Lee 2010)



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал




Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.4. Олон улсын туршлага (Өмнөд Солонгос Улс)

Хүснэгт 9 | Солонгос улсын нийт экспорт, боловсруулсан бүтээгдэхүүний экспорт (1962-2016)



2016 оны байдлаар Солонгос улсын нийт экспортын 60 гаруй хувийг электроник, машины эд анги бүрдүүлж байгаа бөгөөд өдгөө дэлхийн 5 дахь том экспортлогч орон болсон (The observatory of economic complexity, MIT).

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол



Гадаад худалдааны бодлогын түүх



Гадаад худалдааны өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

**ЧӨЛӨӨТ
ХУДАЛДААНЫ
БОДЛОГО**

**ЭКСПОРТЫН
ТАТААС**

**ХУДАЛДААГ
ДЭМЖИХ
БАЙГУУЛЛАГА**



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.4. Олон улсын туршлага (Бүгд Найрамдах Чили Улс)

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БОДЛОГО



Чили улс нь 1959 оноос эхлэн худалдаагаа чөлөөлөх (либералчлах) бодлого явуулсан бөгөөд дэлхийн хамгийн нээлттэй улс орнуудын нэг болсон.

- **Импортын хяналт:** Чили нь импортын бүтээгдэхүүний тоо хэмжээнд ямар нэгэн хязгаарлалт хийдэггүй, импортын 6 хувийн тарифтай гэдгээрээ гадаад орнуудын хувьд худалдааны хамгийн таатай улс юм.
- **Худалдааны хэлэлцээр (Regional Trade Agreement):** Чили нь гадаад улсуудтай худалдааны гэрээ байгуулахаар ихээхэн хүчин чармайлт гаргадаг. Одоогоор 21 бүсийн худалдааны хэлэлцээрт (Regional Trade Agreement) нэгдсэн бөгөөд нийт 57 улстай чөлөөт худалдааны гэрээтэй.

ЭКСПОРТЫН ТАТААС

ХУДАЛДААГ ДЭМЖИХ БАЙГУУЛЛАГА



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.4. Олон улсын туршлага (Бүгд Найрамдах Чили Улс)

ЧӨЛӨӨТ
ХУДАЛДААНЫ
БОДЛОГО

ЭКСПОРТЫН
ТАТААС

1985 оноос Чили улс нь уламжлалт бус экспортлогчиддоо татаас олгож эхэлсэн. Энэхүү бодлогын үр нөлөөний талаар судалсан эмпирик судалгаа байхгүй хэдий ч экспортын хэмжээ болон экспортлогчдын тоо мэдэгдэхүйц өсөж байжээ (Belloc & Maio, 2011).

ХУДАЛДААГ
ДЭМЖИХ
БАЙГУУЛЛАГА



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

3.4. Олон улсын туршлага (Бүгд Найрамдах Чили Улс)

ЧӨЛӨӨТ
ХУДАЛДААНЫ
БОДЛОГО

ЭКСПОРТЫН
ТАТААС

ХУДАЛДААГ
ДЭМЖИХ
БАЙГУУЛАГА

ПРОЧИЛИ (PROCHILE) (1974 оноос хойш)

- Гадаад зах зээлийн судалгаа хийх (тухайн улсын эдийн засаг, нийгмийн дата, хэрэглэгчдийн таашаал, сонголт, худалдан авах зан төлөв болон бусад мэдээллүүд);
- Гадаад зах зээлийн талаарх мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх; (хөтөч гарын авлагаар хангах)
- Чилийн бүтээгдэхүүнүүдийн брендинг хийх, гадаад зах зээлд сурталчилах
- Үзэсгэлэн яармаг зохион байгуулах
- Гадаадын засгийн газрын агентлаг, компани болон худалдааны байгууллагуудтай харилцаа тогтоох



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

ЧИЛИ (1970-аад он)

Орлогын тэгш бус хуваарилалт ихтэй, ядуурлын түвшин 45% хүрсэн, эдийн засаг нь тогтворгүй байгалийн баялгийн хараалд өртсөн улс.

Экспортын 87%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр тусмаа түүхий зэс эзэлсэн хэт уул уурхайд түшиглэсэн орон


ЧИЛИ (2018 он)

Зэсийн экспортоор дэлхийд тэргүүлэгч орон, ядуурлыг 11,7% хүртэл бууруулсан төдийгүй байгалийн баялгаа зохистой ашиглаж чадсан орнуудын нэг.

Экспортын 50%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлдэг, экспортын төрөлжилт ихэссэн байна.



3.4. Олон улсын туршлага (Бүгд Найрамдах Хятад Ард Улс)



Хүснэгт 10 | Хятад улсын экспортын бүтэц

Он	Машин, электроникс	Хувцас, гутал, бусад оёдол	Ашиг малтмал, метал	Бусад
2016	42.7%	14.9%	7.5%	34.9%
2015	42.1%	15.0%	7.9%	34.9%
2010	44.3%	15.4%	7.3%	33.0%
2005	42.3%	17.1%	7.9%	32.7%
2000	29.2%	24.6%	7.2%	38.9%
1995	18.6%	29.6%	9.1%	42.8%
1992	13.6%	35.0%	6.4%	44.9%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

1990 онд Хятад улсын экспорт хувцас болон бусад нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрлэлд тулгуурласан бүтэцтэй байсан болон 2010 он гарсаар тус салбарын эзлэх хувь 35%-15% болж харин машин, электроникийн бүтээгдэхүүний хэмжээ 14%-43% болж өссөн байна (Хүснэгт 8). Солонгос улсын адилаар хөдөлмөрт суурилсан оёдлын салбараас технологит суурилсан нэмүү өртөг ихтэй машин, төнөг төхөөрөмж болон электроникийн салбарт чиглэж байна.

Хятад улсын худалдааны бодлого эхэндээ импорт орлоход чиглэж дараа нь экспортыг нэмэгдүүлэх бодлого баримталж, улмаар Дэлхийн худалдааны байгууллага, бүс нутгийн гэрээ хэлэлцээрт нэгдэж илүү нээлттэй бодлого баримталсан.

4. Дүгнэлт, зөвлөмж

- Сүүлийн жилүүдэд худалдааны салбарын эзлэх хувь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувиас 2 дахин их байна. Иймд гадаад худалдааг эдийн засгийн өсөлтийг дэмжих хангалттай түвшинд хүргэх, түүнд шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.
- Манай улсын гадаад худалдааны иж бүрэн, нэгдсэн бодлого тодорхойлогдоогүй, гадаад худалдааны гүйцэтгэл, идэвхжилт, хэрэгжилтийн үр дүн тун хангалтгүй байна. Тухайлбал гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох урсгал тэнцлийн алдагдал, экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс, төгрөгийн доллартай харьцах ханш зэрэг нь олон улстай харьцуулахад хангалтгүй байна. Түүнчлэн гадаад худалдааны бодлогын хэрэгслийг тодорхойлогч худалдааны гэрээ хэлцлийн ач холбогдол, хамгаалалтын хэмжүүр зэрэг үзүүлэлтүүдээр манай улсын худалдааны бодлогын хэрэгслийн хэрэглээ, ач холбогдол бага байна.
- Засгийн газраас сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих цаашлаад экспорт, импортын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд нэлээдгүй бодлого, хөтөлбөр баталсан хэдий ч үр дүн муутай, биелэлт сайтай бодлого, хөтөлбөр бараг алга байна.
- Монгол улсад Гадаад худалдааг хөгжлийн бодлогын нэг гол тулгуур болгож амжилттай хэрэгжүүлж ирсэн улс орнуудад байдагтай адил гадаад худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх институцийн орчин бүрдээгүй бөгөөд эдгээрийг хослуулан ашиглаж, чиг үүргийг хэрэгжүүлж чадахгүй байна.
- Өмнөд Солонгос, Чили, Хятад зэрэг худалдааны сайн бодлоготой улсуудын туршлагаас харахад гадаад худалдааны бодлогыг шат дараатай, тогтвортой хэрэгжүүлж ирсэн бөгөөд гадаад худалдааг хариуцсан яам, түүний дэргэд экспортыг дэмжих тусгай байгууллага ажиллуулах замаар өөрийн улсын экспортыг дэмждэг байна.



Гадаад худалдааны
бодлогын түүх



Гадаад худалдааны
өнөөгийн нөхцөл байдал



Гадаад худалдааны
бодлогын ач холбогдол



Дүгнэлт, зөвлөмж

- Ихэнх улс оронд гадаад худалдааг дангаар хариуцан ажилладаг яам, түүний дэргэд гадаад худалдааг дэмжих зохицуулалттай бие даасан байгууллага ажиллаж байна. Харин Монгол улсад гадаад худалдааг дангаар нь хариуцдаг яам байхгүй (Монгол улсын гадаад худалдааны бодлогыг Гадаад харилцааны яамны “Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар” хариуцан ажилладаг). Манай оронд гадаад худалдааг дангаар хариуцсан яам байгуулах шаардлагатай байна. Гадаад худалдааг дангаар хариуцах яам бий болсноор төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц сайжрах, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийгдэх, үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой болно. Тус яамны жишиг бүтэц нь дараах байдалтай байж болох юм.

